

ГЛОБАЛЧЛАЛЫН ЭРИНИЙ МОНГОЛ, АМЕРИКИЙН ХУДАЛДАА, ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГ ХАНДЛАГА

*Ц.Баатар**

Одоогоос 20 жилийн өмнө Монгол Улс-Америкийн Нэгдсэн Улсын хооронд дипломат харилцаа тогтоосон тухай монголчуудын олон жил хүсэн хүлээсэн баярт мэдээ Монголын удам тал нутгаар түгэн тархаж, идэр есийн жаврыг уярааж, урин дулаан салхины угтал болж, буурай хөгжилтэй, Азийн жижиг орон Монголыг дэлхийд дахин нээсэн түүхэн тэмдэглэлт үйл явдал болж байсныг өнөөдөр нэхэн санахад нэн таатай байна. Тэр түүхэн цаг үед хорвоод мэндэлсэн Монголын шинэ үеийнхэн эрийн цээнд хүрч, тэдний элч төлөөлөгчид өнөөдөр эрх чөлөө, ардчиллын өлгий АНУ-д дэлхийн жишигт нийцсэн боловсрол эзэмшиж явна.

Өнгөрсөн богино хугацаанд Монгол Улсад хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэсэн, хувийн хэвшил зонхилсон зах зээлийн эдийн засгийг бэхжүүлж, тогтвортой ардчиллыг төлөвшүүлэн хөгжүүлэхэд АНУ бүх талаар туслан дэмжиж, үнэлж баршгүй их хувь нэмэр оруулж байгаад монголчууд гүнээ талархаж, эрх чөлөө, ардчиллын өмөг түшиг, авран хамгаалагчаа хэмээн үзэж гүн хүндэтгэл үзүүлж, итгэл найдвар тавьж байдаг билээ. Энд нэг зүйлийг онцлон тэмдэглэхэд төр улсаа төлөөлж Монгол Улсад сууж байсан, сууж байгаа АНУ-ын дипломатчид Монгол Улсын хөгжлийн төлөө Монголын иргэн шиг өөриймсэг сэтгэлээр санаа тавин, уйгагүй хичээл зүтгэл гарган аль болох туслахсан, болохгүй бүтэхгүй байгаа зүйлийг нь засан заларуулж болгохсон гэсэн нэгэн үзүүрт сэтгэлээр ажиллаж ирсэн явдалд монголчууд гүнээ талархаж явдгийг хэлэх гэсэн юм.

Хоёр орны харилцааны туулж ирсэн 20 жилийн өндөрлөгөөс харахад харилцаа, хамтын ажиллагаа өнөөдөр иж бүрэн түншлэл, гуравдахь хөршийн харилцаа хүртэл ойр дотно, өндөр дээд түвшинд өрнөн хөгжиж байна. Олон улсын харилцааны түүхэнд ховорхон тохиолдох энэхүү хүрсэн түвшин олон улс орны сонирхлыг ихээхэн татаж, анхааралтай ширтэн харж байгаа нь түүний өвөрмөц онцлогийг илтгэн харуулж буй хэрэг.

АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Буш 2005 оны өвлийн эхэн сард Монгол Улсад айлчилсан нь хоёр орны харилцааны шинэ үеийг нээж өгсөн түүхэн ач холбогдолтой үйл явдал болсон билээ.

Глобалчлалын өнөөгийн эринд хоёр улсын хооронд улс төр, эдийн засгийн харилцаа идэвхтэй, эрчимтэй хөгжих эрх зүйн үндэс суурь нэгэнт

* Ц.Баатар - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

бий боллоо. Өнөөгийн мэдээллийн технологи, тээврийн үсрэнгүй хөгжил нь газар зүй, орон зай, цаг хугацааны ойлголтыг өөрчлөв. Хоёр орны төр засгийн болон иргэд, хувийн хэвшлийнхэн хоорондоо хоромхон хугацаанд харилцах, мэдээлэл солилцох өргөн боломж нэгэнт бүрдлээ.

Манай хоёр улс эрх чөлөө, ардчилал, чөлөөт зах зээлийн үнэт зүйлсийг эрхэмлэн дээдэлдэг нь худалдаа, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааг өрнүүлэн хөгжүүлэхэд ихээхэн чухал үүрэг гүйцэтгэж байна. Ялангуяа хоёр улсын Ерөнхийлөгч нарын 2004, 2005 онд гаргасан Хамтарсан мэдэгдэл нь ардчилсан, эрх чөлөөг эрхэмлэгч хоёр орны хамтын үнэт зүйлс, стратегийн нийтлэг эрх ашигт тулгуурласан иж бүрэн түншлэлийн шинэ эрин үеийг зарлан тунхагласан билээ. Энэ хосгүй түүхэн ач холбогдолтой үйл явдал нь АНУ-аас Монгол Улсад суух Элчин сайд асан Альфонсе ла Порта, доктор Эндрю Ж.Кричфильд нарын хэлсэнчлэн “АНУ-Монголын харилцаа нь нягт сүлжсэн эдлэл мэт бөх, харилцан уялдаатай” өрнөн хөгжих нэн таатай боломжийг нээж өгсөн юм.

Өнгөрсөн хугацаанд хоёр орны хамтын ажиллагаа хэрхэн өрнөн хөгжиж ирснийг энд тоймлон авч үзье.

Нэг. Худалдаа, хөрөнгө оруулалт

Худалдаа. Өнгөрсөн хугацаанд Монгол, АНУ-ын худалдааны эргэлтэд ихээхэн ахиц өөрчлөлт гарлаа. Өнөөдөр АНУ Монголд хөрөнгө оруулалтаараа тэргүүлж буй таван орны нэг төдийгүй гадаад худалдааны 3 дахь томоохон түнш боллоо.

Монгол-АНУ хоорондын худалдааны хууль эрх зүйн орчны хувьд 1991 онд хоёр талын байгуулсан Худалдааны хэлэлцээр, 1994 оны Хөрөнгө оруулалтыг харилцан хамгаалах, хөхиүлэн дэмжих тухай хэлэлцээр, 2004 онд байгуулсан Худалдаа болон хөрөнгө оруулалтыг хөгжүүлэх тухай хэлэлцээрүүд орж байна. АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Бушийн Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр гаргасан хоёр улсын хамтарсан Мэдэгдэлд Худалдаа, хөрөнгө оруулалтын ерөнхий хэлэлцээрийн хүрээнд “хоёр талын эдийн засаг, худалдааны харилцааг улам бэхжүүлнэ” гэж тунхагласан билээ.

1999-2006 оны хооронд хоёр улсын худалдааны эргэлт 1,3 тэрбум ам.долларт хүртэл өсөн нэмэгдлээ. Манай оёмол сүлжмэл бүтээгдэхүүнд АНУ-аас олгосон нэн тааламжтай худалдааны нөхцөл нь Монгол Улсаас АНУ-д гаргах бүтээгдэхүүний экспортын хэмжээ нэмэгдэхэд чухал хүчин түлхэц болсон билээ. Хөнгөлөлтийн хугацаанд манай үйлдвэрлэгчид 634 сая ам.долларын оёмол, сүлжмэл бүтээгдэхүүнийг АНУ-д экспортложээ. Үүний ач буянаар манай 20

гаруй мянган оёдолчин бүсгүйчүүд маань хоёр орны худалдааны гүүр болж, АНУ-ын зах зээлээс шилжилтийн хүнд бэрх цаг үед ар гэрийнхээ амьдралыг залгуулж байлаа. Энэ квот 2005 оны нэгдүгээр сард дууссан. Үүнийг дагалдан гадаадынхан хөрөнгө оруулалтаа татаж, үйлдвэрлэл хумигдан, экспорт эрс буурсан билээ. Гэсэн хэдий ч цаашид харилцан ашигтай худалдаа хөгжүүлэх өргөн нөөц боломж байгаа бөгөөд ойрын хугацаанд өмнөх түвшингээс ч өсөх магадлал бий.

Өнгөрсөн хугацаанд хоёр орны худалдааны эргэлт хэр зэрэг ахиц өөрчлөлттэй явж ирснийг дараах хүснэгтээс үзнэ үү.

Монгол, АНУ- худалдааны эргэлт
/1999-2006/ сая ам.доллар

	1999	2000	2001	2002	2003	2004	2005	2006
Экспорт	78,0	130,2	144,5	165,7	140,4	153,8	150,4	119,9
Импорт	31,5	28,4	14,9	23,4	23,6	47,5	36,7	44,0

Эх сурвалж: Монгол Улсын эдийн засаг, гадаад худалдааны цагаан ном, УБ., 2006, Гадаад худалдааны гаалийн мэдээлэл 2007.

Манай гадаад худалдааны эргэлтэд хоёр орны худалдааны эзлэх хувийн жин /сүүлийн 4 жилд, %-иар/

	Үзүүлэлт	2003	2004	2005	2006
1.	Экспортод эзлэх хувийн жин,%	23,3	17,9	14,2	4,5
2.	Импортод эзлэх хувийн жин,%	2,9	4,6	3,4	3,1

Эх сурвалж: Монгол Улсын эдийн засаг, гадаад худалдааны цагаан ном, УБ., 2006, Гадаад худалдааны гаалийн мэдээлэл 2007.

Хүснэгтээс үзэхэд АНУ-д гаргаж буй манай экспорт, АНУ-аас авч буй импорт харилцан адилгүй хэлбэлзэлтэй байгаа нь харагдаж байна.

Монгол Улс одоогоор АНУ-тай Чөлөөт худалдааны хэлэлцээр хараахан байгуулаагүй хэдий ч энэхүү хэлэлцээрийг ойрын хугацаанд байгуулахаар шуурхай ажиллаж байна. Энэхүү хэлэлцээрийн суурь хэлэлцээр болох 2004 оны 7 дугаар сард байгуулсан Худалдаа болон хөрөнгө оруулалтын ерөнхий хэлэлцээр чухал ач холбогдолтой юм. Мөн түүнчлэн Давхар татвар ноогдуулахгүй байх тухай хэлэлцээр байгуулахын тулд хоёр талын холбогдох байгууллагууд ажиллаж байна. Монгол Улс АНУ-тай ойрын хугацаанд чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулж чадвал манайд экспортын бараа бүтээгдэхүүний

нэр төрөл болон хөрөнгө оруулалт нэмэгдэж, тариф буурах, улмаар тэглэх зэрэгт шийдвэрлэх ач холбогдолтой үйл явдал болох юм.

Хөгжлийн эдийн засгийн онолын хувьд жижиг орон том гүрэнтэй чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах нь жижиг орны эдийн засгийн өсөлт хөгжлийг дэмжсэн томоохон дэмжлэг болдог. Энэ утгаараа хөрш Орос, Хятадтай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулахаас өмнө АНУ-тай энэ гэрээг байгуулахад Монгол Улс ихээхэн ач холбогдол өгч байгаа билээ. Энэ нь цаашлаад Монгол Улс Зүүн Азийн чөлөөт худалдаа, эдийн засгийн интеграцид нэгдэн орох үүд хаалгыг нээж өгөх стратегийн чухал ач холбогдолтой хүчин зүйл болох билээ.

Хөрөнгө оруулалт. Улс төрийн харилцаа өрнөн хөгжихийн хэрээр Монголд АНУ-ын хөрөнгө оруулалт өсөн нэмэгдэж, өргөжин тэлсээр байна. Зах зээлийн зүй тогтлын дагуу хоёр орны бизнесменүүд идэвхтэй үйл ажиллагаа явуулж ирэв. Өнөөгийн байдлаар манайд АНУ-ын хөрөнгө оруулалттай 120 орчим компани өссөн дүнгээр 51,2 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгээд байна. АНУ-ын хөрөнгө оруулалт уул уурхай, мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах, хөнгөн үйлдвэрт зонхилж байна. Эдгээрээс томоохон хөрөнгө оруулалттай компани гэвэл Монгол Амикал, GL-Монполимет, Рок ойл, Вагнер Ази тоног төхөөрөмж зэрэг компаниуд юм. Вагнер Ази сүүлийн 5 жил дараалан Монголын TOP-100 аж ахуйн нэгээр тогтмол шалгарч ирлээ. Түүнчлэн ноос ноолууран эдлэлийн чиглэлээр нэртэй брендийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг Монгол Амикал зэрэг олны танил болсон Америкийн хөрөнгө оруулалттай олон компаниудыг нэрлэж болох байна.

Сүүлийн үед АНУ-ын хөрөнгө оруулагчид манай уул уурхайн салбар болон эдийн засгийн чөлөөт бүсүүдэд хамтран ажиллах сонирхол өсөх чиг хандлага ажиглагдаж байна. Хэдийгээр тооны хувьд их биш ч гэсэн манай зарим овсгоотой бизнесменүүд ч Америкт хөрөнгө оруулалт хийж, компани байгуулан амжилттай ажиллаж байна.

Өнөөгийн байдлаар бүрэн бус мэдээгээр Америкийн бүх муж улсын 80 гаруй хотод манай 20 мянга орчим иргэд амьдарч, ажиллаж, суралцаж байна. Зарим хотуудад чайна таун маягийн жижигхэн монгол таун бий болж эхэллээ. Энэ бүхэн хүмүүс хоорондын харилцааны бат бэх гүүр болж байна.

АНУ-д суугаа элчин сайд Р.Болдын судалж үзсэнээр “АНУ-д байгаа монгол иргэдээс ах дүү, аав, ээждээ үзүүлдэг дэмийг мөнгөн дүнгээр илэрхийлбэл АНУ-аас Монгол Улсад үзүүлдэг хөгжлийн албан ёсны тусламжаас хэд дахин их, манай батлан хамгаалах жилийн зардлаас ч хол давсан” нь Америкийн хөгжлийн тусламжийн бас нэгэн илрэл юм.

Судалгаанаас үзэхэд шилжилтийн жижигхэн эдийн засагтай, буурай хөгжилтэй, тарчигхан амьдралтай манай иргэд АНУ-ын виз хүсэх,

үр хүүхдээ сургах, тэнд хар бор ажил хийх гэх мэтээр улсынхаа жилийн төсвөөс ч хол давсан хөрөнгө оруулалтыг АНУ-д оруулдаг байна.

АНУ-аас албан ёсны шугамаар олгож буй сургалтын тэтгэлгийн хэмжээг нэмэгдүүлэхийг санал болгосны дагуу АНУ-ын ЭСЯ-наас 2004 онд 500 мянган ам.долларыг сургалтын тэтгэлэгт зарцуулахаар шийдвэрлэснээ албан ёсоор мэдэгдсэн билээ. Хөгжлийн албан ёсны тусламжаас гадуур Соросын сан зэрэг төрийн бус байгууллагууд сайн санаат хувь хүмүүс Монгол Улсын хөгжлийн нэгэн тулах цэг болсон хүмүүн капиталд түлхүү анхаарч оюуны хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлсээр байгаа нь үнэхээр олзуурхууштай хэрэг. Зөвхөн өнгөрсөн онд гэхэд л 912 хүүхэд сурах багтаамжтай Улаанбаатарын Америк иж бүрэн цогцолбор сургууль үүдээ нээлээ. Ирээдүйд чиглэсэн оюуны хөрөнгө оруулалтад АНУ-ын хөрөнгө оруулагчид хичнээн их анхаарал тавьж байдгийн бас нэгэн илрэл нь энэ сургууль гэж үзэж байна.

Энэ дашрамд Америкийн хөрөнгө оруулагчдыг Монголд татах талаар Умард Америк Монголын Бизнес Зөвлөл идэвхи санаачлагатай ажиллаж ирснийг тэмдэглэхэд таатай байна.

Хоёр. Эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа

АНУ-ын Экспорт-Импорт банк бизнесменүүддээ Монголд бүтээгдэхүүн экспортоход дэмжлэг үзүүлэх, Монголын төрийн болон хувийн секторт зээлийн баталгаа гаргах зэргээр хамтран ажиллахаар болсон нь хоёр улсын эдийн засгийн харилцааг өргөтгөн хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Энэхүү хамтын ажиллагааны эхлэл болгож манай МИАТ компани шинэ Бойнг онгоц болон төмөр замын зүтгүүр худалдан авахад зээлийн баталгаа гаргаж өгөхөөр боллоо. Энэ бүхэн нь шилжилтийн эдийн засгийн хүндрэлийг даван туулахад үзүүлж буй тусламж дэмжлэгийн нэг хэлбэр хэмээн үзэж байна.

Түүнчлэн АНУ-ын “Эксим” банк Монголын аж ахуйн нэгжүүдэд зээлжих эрх нээн, санхүүгийн баталгаа гаргах болсноор манай бизнесийнхэн бизнесээ өргөтгөн хөгжүүлэхэд том дэмжлэг, нэн таатай боломж нээгдлээ.

Цаашдаа хоёр орны хооронд агаарын харилцааны хэлэлцээр байгуулах нь Монгол Улс бүс нутгийн интеграцлалд хамрагдах, АПЕК-т гишүүнээр элсэхийн нэг бэлтгэл, энэ салбарт өрсөлдөөнийг бий болгох стратегийн чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

АНУ манай улсыг АПЕК-т гишүүнээр элсэхэд дэмжлэг үзүүлэхээ илэрхийлж байгаа нь Монгол Улс энэ байгууллагад элсэж, АПЕК-ийн гишүүн орнуудын хүрээнд өрнөн хөгжиж буй олон талт хамтын ажиллагаанд идэхитэй оролцох түүхэн боломж нээгдэхэд тус болно гэдэгт бид итгэлтэй байна.

Гурав. Хөгжлийн албан ёсны тусламж

Монгол Улс ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн эхэн үеэс АНУ тууштай дэмжиж тусламжийн гараа харамгүй сунгасан томоохон хандивлагчдын нэг билээ. Өнөөдөр Америкийн хөгжлийн хөтөлбөр Монголын нийгэм эдийн засгийн бараг бүх салбарыг хамарч байгаагаараа онцлогтой.

АНУ 1991 оноос Монгол оронд өрнөж буй ардчилал, шилжилтийн эдийн засагт туслах зорилгоор олон төслүүд хэрэгжүүлж ирлээ. Төслүүд эхний үед эдийн засаг, бизнесийн шинэчлэлд зориулж байсан бол сүүлийн жилүүдэд хүрээгээ тэлж хөдөөгийн бизнесийг хөгжүүлэх, гэр санаачлага төслийн хүрээнд өрхийн орлогыг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулахад түлхүү анхаарч ирлээ. Дээрхи төслүүд нь үндсэндээ салбарын чиглэлийн тусламжийн хүрээнд хэрэгжиж байна. Түүнчлэн улс төр, эрх зүй, авилгатай тэмцэх, иргэний нийгмийн чадавхийг бэхжүүлэх гэх мэтээр бодлогын чиглэлийн төслүүд ч амжилттай хэрэгжиж байна.

АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг нь хөгжиж байгаа орнуудад үзүүлж буй хөгжлийн тусламж дэмжлэгийн хүрээн дэх төсөл хөтөлбөрүүдийг гардан хариуцаж, хэрэгжүүлдэг Засгийн газрын агентлаг болохынхоо хувьд Монгол Улсад хөгжлийн тусламж үзүүлэх, хоёр талын хамтын ажиллагааг өрнүүлэн хөгжүүлэх, тусламжийн хэрэгжилтийг хангахад санаачлагатай, үр бүтээлтэй ажиллаж ирлээ.

ОУХА Монгол Улсад үзүүлэх анхны тусламжийн хөтөлбөрөө 1991 оноос эхэлж, мөн ондоо 10 сая ам.доллартай тэнцэхүйц санхүүгийн яаралтай тусламж үзүүлсэн билээ. Түүнчлэн эрчим хүчний тулгамдсан асуудлыг шийдвэрлэх үүднээс 50 сая ам.долларын өртөг бүхий эрчим хүчний тоног төхөөрөмж болон техникийн тусламж үзүүлэв. ОУХА-ийн хөтөлбөрүүд нь эхний үед эрүүл мэнд болон хүнсний яаралтай тусламж үзүүлэхэд чиглэж байсан бол аажмаар эдийн засгийн болон улс төрийн шинэчлэлийг гүнзгийрүүлэхэд ихээхэн анхаарал тавих болсон билээ.

ОУХА Монгол Улстай 2004-2008 онд хамтран ажиллах стратегийн баримт бичгийг 2003 онд баталсан. Энэхүү стратегийн үндсэн зорилго нь Монгол Улсад эрх чөлөө, ардчилал, зах зээлийн эдийн засгийг хөгжүүлэх, сайн засаглалыг бэхжүүлэхэд үргэлжлүүлэн туслан дэмжихэд чиглэж байна.

Өнгөрсөн 15 жилийн хугацаанд АНУ зөвхөн ОУХА-ийн шугамаар манай улсад 200 сая орчим ам.долларын хөгжлийн тусламж үзүүлээд байна. Хэдийгээр албан ёсны тоо баримт байхгүй ч гэсэн өнгөрсөн хугацаанд Америкийн өдий төдий тусламжийн сан, хувийн сайн дурын байгууллага, корпорац, их сургууль, шашны бүлгүүд, хувь хүмүүсээс үзүүлсэн хандив тусламж дээрхи тооноос хэд дахин их гэдгийг баттай хэлж болох байна.

АНУ-аас Олон Улсын Хөгжлийн Агентлагийн шугамаар Монгол Улсад үзүүлсэн хөгжлийн тусламж (1991-2006)

сая ам.доллар

1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004	2005	2006
4.06	1.47	34.14	13.33	11.78	8.88	8.11	14.04	12.82	9.41	3.24	16.00	8.65	20.65	12.29	7.32

Сүүлийн үед АНУ-ын хөгжлийн тусламж нь манай улсад хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийн хөгжлийг дэмжих, ардчилал болон засаглалыг бэхжүүлэх гэсэн 2 үндсэн чиглэлд түлхүү анхаарал тавьж байна. Хөгжлийн тусламж дэмжлэг нь хөдөөгийн хувийн бизнес эрхлэгчид бизнесийн мэдээлэл шуурхай авах, хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, санхүүгийн салбарт шинэчлэл хийх, Монголын экспортын бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулах зэрэгт зохих үр дүнгээ өгч байна. Түүнчлэн ардчилал болон засаглалыг бэхжүүлэх төслийн хүрээнд үзүүлж буй тусламж дэмжлэг нь шүүх засаглалыг дэмжих, сонгуулийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, парламентийн шинэчлэл зэрэгт чиглэж байна.

2006 онд олгохоор болсон 7,3 сая ам.долларын тусламжийн хүрээнд дээрхи төслүүдээс гадна өмнө нь хэрэгжүүлж байсан “Хөдөөгийн бизнес мэдээ” сонин гаргаж хөдөөгийн малчдын талархаж хүлээж байгаа “Говийн бүсийн эдийн засгийн хөгжүүлэх санаачлага” төслийг үргэлжлүүлэх, Шүүх засаглалын шинэчлэл, сайн засаглалыг дэмжих, иргэний нийгмийн чадавхийг бэхжүүлэх, авилгатай тэмцэх зэрэг төслүүдэд зориулж байна.

АНУ-ын ОУХА-ын шугамаар хэрэгжүүлж ирсэн төслүүд нь Монгол Улсын хөрөнгө оруулалтын болон бизнесийн орчинг сайжруулах, төрийн албан дахь авилгал, хүнд суртлыг арилгах, албан татварын тогтолцоонд шинэтгэл хийх, төрийн өмчийн хөрөнгийн хувьчлалыг үргэлжлүүлэх, бусад хууль эрх зүйн болон хөрөнгө оруулалтын орчинг тогтвортой болгох, эдгээр салбарт гадаад, дотоодын шууд хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн орчинг бүрдүүлэх зэрэгт зохих үр дүнгээ өгч байна.

Хөгжлийн тусламжийн ирээдүйд чиглэсэн, хамгийн чухал чиглэлийн нэг бол Монголын шинэ үеийнхэнд дэлхийн жишигт нийцсэн боловсрол эзэмшихэд үзүүлж буй оюуны хөрөнгө оруулалт юм гэдгийг энд онцлон тэмдэглэхийг хүсч байна.

Өнөөгийн байдлаар бүрэн бус мэдээгээр манай 1000 гаруй охид хөвгүүд төрийн сан, байгууллагын, хувийн зардал, бусдын тэтгэлгээр Америкийн их дээд сургуулиудад суралцан дэлхийн жишигт нийцсэн чанартай боловсрол эзэмшиж байна. Зөвхөн Хавайд гэхэд л 100 орчим оюутан суралцаж байх жишээтэй. Тэдний зарим нь мэдээллийн технологи, эдийн засаг, физик, математик, биологи, биохими, биотехнологийн чиглэлээр эрдмийн зэрэг хамгаалан Америкийн их

дээд сургуулиудад уригдан ажиллаж байна. Энэ бол монголчуудын оюуны чадавхийг харуулсан нэгэн үзүүлэлт гэж болох юм. Америкийн их дээд сургуульд уригдан ажиллах боломж тэр болгон хүнд олддоггүй. Гагцхүү оюун ухааны сорууд л тэнд уригддаг.

АНУ-ын их дээд сургуульд суралцаж өндөр боловсрол эзэмшсэн 200 гаруй охид хөвгүүд эх орондоо эргэн ирж төрийн болон хувийн хэвшлийн салбарт үр бүтээлтэй ажиллаж байна. Түүгээр ч үл барам тэд АНУ-д төгсөгчдийн Холбоо байгуулан үе тэнгийнхэнээ АНУ-д суралцахад нь дэмжлэг үзүүлж байна.

Хөгжлийн албан ёсны тусламжийн хүрээнд Америкийн Энх Тайвны Корпусын шугамаар үзүүлж буй хүмүүнлэгийн тусламж дэмжлэгийн тодорхой хэсэг мөн л оюуны хөрөнгө оруулалтад чиглэж ирэв. Өнгөрсөн 15 жилийн хугацаанд энэ байгууллагын шугамаар 576 сайн дурынхан манай төвөөс алслагдсан хөдөөгийн зах хязгаар нутгийн залуу үеийнхэнд англи хэл заах, хоёр орны соёлоос харилцан суралцах зэргээр хүмүүс хоорондын харилцаа, итгэлцлийг бэхжүүлэх, Монголыг америкчуудад таниулах гүүр болж байна. Өнгөрсөн онд гэхэд л манайд 103 сайн дурынхан ажиллаж байгаа гэсэн мэдээ бий. Энэ хирээр Монголд элэгтэй америкчуудын тоо өсөн нэмэгдэж, хүмүүс хоорондын харилцааг бэхжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж байна. Энэ дашрамд өгүүлэхэд хоёр орны харилцааг хөгжүүлэхэд америкийн эгэл жирийн иргэд үнэлж баршгүй хувь нэмэр оруулж ирснийг энд тэмдэглэхэд таатай байна.

Хоёр талын соёлын харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд Смиционны хүрээлэнгээс Монголын умард хэсэгт хэрэгжүүлж буй соёл түүхийн судалгаа, АНУ-ын Боловсролын яамны дэмжлэгтэй Америкийн Монгол судлалын төв зэрэг үр өгөөжтэй төсөл амжилттай хэрэгжиж байна. Түүнчлэн АНУ-ын Элчин сайдын яамнаас Монголын сүм хийдийг сэргээн засварлах, түүх соёлын үнэт өвийг хамгаалах чиглэлээр урлаг соёлын байгууллагуудтай 2001 оноос эхлэн хамтран ажиллаж ирлээ. 2005-2006 онд энэхүү төслийг үргэлжүүлж 30 мянган ам.долларын тусламж үзүүлсэн билээ. Төслийг Аризонийн их сургуулийн эрдэмтэд хамтран хэрэгжүүлж байна.

АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Буш 2002 онд Хөгжиж байгаа орнуудад зориулж 5 тэрбум ам.доллар бүхий Мянганы Сорилтын Сан (МСС) нээснээ дэлхий нийтэд зарласан билээ. Түүний шалгуур үзүүлэлтийг Монгол Улс 2004 оноос хойш жил дараалан хангаж МСС-гаас тусламж хүртэх орны тоонд Монгол Улс багтаж ирлээ. Манай улсын боловсруулж МСС-д хүргүүлсэн боловсрол, эрүүл мэнд, дэд бүтцийн чиглэлийн төслүүд шалгарч өнөө жилээс хэрэгжиж эхлэх гэж байна. Энэхүү МСС-д хүргүүлсэн төслүүдийг олон нийтийн дунд явуулсан нээлттэй хэлэлцүүлгийн үр дүн, Засгийн газраас баталсан

үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэл зэрэгтэй уялдуулан боловсруулсан тул түүнд Монгол Улс ихээхэн ач холбогдол өгч байна.

Дүгнэлт

Глобалчлалын өнөөгийн эринд 20 жил гэдэг бага биш хугацаа. Өнгөрснийг эргэн харахад хоёр улсын худалдаа, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа өнөөгийн хүрсэн түвшинээс ч илүү өрнөн хөгжих бодит нөөц боломж байсныг үгүйсгэх аргагүй. Америк гэдэг агуу том гүрэн учир дэлхийн хэмжээний тулгамдсан асуудал эн тэргүүнд тавигддаг нь зүйн хэрэг. Энэ утгаараа Америкийн хувьд төдийлэн ач холбогдолгүй жижиг гэмээр асуудалд тэр болгон шуурхай хандах боломж ч хязгаарлагдмал. Энэ мэт асуудалд хандах том, жижиг хоёр улсын ялгаа “зовлон” байгаа боловч стратегийн нийтлэг ашиг сонирхол тулгамдсан асуудлыг шуурхай шийдвэрлэх гол хүчин зүйл болж ирлээ.

Цаашид АНУ-ын тусламж дэмжлэг, хамтын ажиллагааг аль салбарт хэрхэн илүү үр өгөөжтэй ашиглах вэ гэдэг тал дээр бид анхаарч өөрийн онцлог, гадаад, дотоод хүчин зүйлсийн нөлөө тусгалыг олон талаас нь тооцож дараах хэдэн чиглэлд чухал ач холбогдол өгч, түлхүү анхаармаар санагддаг. Үүнд:

- Манай орны хамгийн үнэт баялаг хүмүүн капитал болох монголын залуу үеийхэнд дэлхийн жишигт нийцсэн боловсрол эзэмшихэд тусламжийн бодлогыг төвлөрүүлж жил бүр 360-400 оюутныг тэтгэлэгт сургалтанд хамруулах (өнөөгийн хөгжлийн тусламжийн дунджаар тооцов);

- Хоёр орны хамтын ажиллагааны хамгийн ирээдүйтэй салбарын нэг болох биотехнологийн салбарт хамтын ажиллагааг эрчимжүүлэх;

- Хоёр орны хооронд чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах үйл явцыг хурдасгах;

- Бүс нутгийн хамтын ажиллагааны чиглэлд бүсийн гол тоглогч АНУ-аас дэмжлэг тусалцаа авах нь Монгол Улс АПЕК болон Зүүн Азийн чөлөөт худалдаа, эдийн засгийн интеграцид нэгдэн ороход шийдвэрлэх хүчин зүйл байх болно гэж үзэж байна.

Шилжилтийн, жижиг эдийн засагтай, буурай хөгжилтэй, эрх чөлөөний төлөө тэмцсэн, зовж зүдэрсэн, өнөө ч амаргүй зам, амьдрал туулж яваа монголчууд бидний хувьд нийгмийн шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудлууд багагүй бий. Энэ хүнд цаг үед Бурханаас хол Монголчуудад эрх чөлөө, ардчиллын өлгий Америкийн Ерөнхийлөгч Ж.Бушийн хэлсэнчлэн зовлон жаргалаа хуваалцсан “ахан дүүс шиг хамтдаа” байх болтугай.